

НИГҮҮЛСЛИЙН АЯЛАЛ

УГТАЛ НИГҮҮЛСЭЛ

4 долоо хоногийн хичээл

ДЭН БҮҮН

УГТАЛ НИГҮҮЛСЭЛ

4 долоо хоногийн хичээл

ДЭН БҮҮН

2024 он

Угтал Нигүүлсэл
Дэн Бүүн

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Зохиогчоос урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэхүү номын аль ч хэсгийг хуулбарлах, хайлтын системд хадгалах, цахим, хуулбар, бичлэг зэрэг ямар нэгэн хэлбэрээр дамжуулах, ашиглахыг хориглоно. Хэвлэмэл хэлбэрээр нь товч эшлэл байдлаар ашиглах үл хамаарна.

Хавтасны дизайныг: Роб Монасели
Доторх дизайныг: Шэрон Пэйж
Орчуулсан О.Дөлгөөн
Хянасан С.Бямбасүрэн

АГУУЛГА

1-р долоо хоног
Бурхан хаана байна вэ?

4

2-р долоо хоног
Корнел Петр хоёр

20

3-р долоо хоног
Хэн гэдгийг минь хэлдэг Бурхан

37

4-р долоо хоног
Би сонгогдох дуртай

53

1-Р ДОЛОО ХОНОГ

БУРХАН ХААНА
БАЙНА ВЭ?

Есүсийн Иоханд илчилсэн Ариун Библийн хамгийн сүүлийн ном сонирхлыг минь үнэхээр их татдаг. Супер баатрын дүр төрхөөр дүүрэн энэ ертөнцөд гал улаан морьд, ёроолгүй нүхнээс гарах араатан, царцааны армийг сонирхохгүй хэн байх вэ дээ? Бурханы түүхийг хуурамч гэж боддог хүмүүс Илчлэлт номыг уншаарай! Энэ ном бусад номноос илүү Бурханы нэрээр дүүрэн байдагт би бас дуртай. Зохиогч нь яг л Библийн бусад жаран таван ном дээр тармуур гүйлгэж, бүх нэрсийг нь цуглуулсан гэлтэй. “Байгаа, байсан, мөн хожим ирэх Төгс хүчит Эзэн Бурхан “Альфа ба Омега нь Би байгаа юм” гэж Эзэн Бурхан айлдаж байна” (1:8).

Энэ нэр Бурханыг яг цаг хугацаанд нь тавьдаг. Энэхүү Бурханы Илчлэлт бол манай түүхийн эхлэл, эхний Альфа буюу А үсэг, бидний түүхийн төгсгөл, сүүлчийн Омега буюу Я үсэг юм. Хүмүүн бидний түүх энэ л Бурханы оршихуйн завсарт хавчуулаастай байдаг. Бидний оршин тогтнох түүхийг илэрхийлдэг А-аас Я хүртэлх бүх үсэг Бурханы цагаан толгойд бий. Эхний амьсгалаас эцсийн амьсгал хүртэл, бүр түүнээс цааш ч гэсэн амьдрал маань Бурханы оршихуйд байсаар байх болно.

Бурхан бидэнтэй холбоогүй мөч гэж нэг ч үгүй. Энэ нь Ромын эзэнт гүрэн болон түүний араатанлаг засаглалын дараа зовж шаналсан хүмүүсийг сэргээх сайн мэдээ байсан юм. Илчлэлтийн түүхээр дамжуулан хүмүүс Бурханы түүх ба үйлсийн дотор шуудхан орох боломжтой болсон. Тэд дэлхийн тавцанд мартагдсан тоглогчид биш, харин Төгс Хүчит Бурханы хувьд чухал хүмүүс байсан юм. Тэд бол өөрсдийнх нь одоо цагийн хямралын үед ч, мөн цаг хугацаа өнгөрсөн ч тэдэнтэй төдийгүй хүн бүртэй хамт байсан, цаашдаа ч ухамсрын дараагийн мөчид тэдэнтэй хамт байх Бурханы оршихуйд амьдарч байлаа.

“Угтал нигүүлсэл” гэдэг хэллэгийг ашиглахдаа, бид Бурханыг эрж олдог биш харин биднийг эрэн хайж, олдог Бурханы тухай ярьдаг гэж ойлгодог. Учир нь Бурхан үргэлж энд байсаар байсан. Бурхан бол өнгөрсөн, одоо, ирээдүй билээ. Тийм учраас Илчлэлт нь эхлэл ба төгсгөл, Альфа ба Омега (Грек цагаан толгойн эхний ба сүүлийн үсэг) болох Бурханы тухай өгүүлдэг.

Та Бурхантай хэрхэн уулздаг бэ? Хүн төрөлхтний тухай эртний судруудыг судалж байгаад тэнгэрлэг хурууны хээг олсон уу? Мэдээ үзэж байгаад одоогийн болж байгаа зүйлтэй хамаатай Бурханы оролцоог олж мэдсэнээрээ юу? Өглөөний тэнгэрийг ажиглан хараад, ирээдүйд болох зүйлсийг эрэгцүүлэн бодоод уу? Мэдээж, Бурхан эдгээрийн дотор байгаа. Өнгөрсөн, одоо, ирээдүй шүү дээ. Бидний мэдэх, хүлээн зөвшөөрөх, туулж үзсэн бүх зүйлийн дотор Бурхан байгаа. Өнгөрсөн, одоо, ирээдүй дэх амьдралдаа Бурхантай бүрэн танилцах хаалгыг нээж өгдөг зүйлийг Угтал Нигүүлсэл гэж хэлээд байгаа юм. Илчлэлтийг хүлээж авах боломжтой болгохын тулд биднийг мэдэхээс ч, хайхаас ч, туулахаас ч өмнө Бурхан урьтаж явдаг.

Өнгөрсөнд хамт байсан, одоо ч хамт байгаа бөгөөд ирээдүйгээс ирэх Бурхан хүмүүст сануулах хэрэгтэй болсон учраас Илчлэлт номыг бичсэн гэж би боддог юм. Биднийг үргэлж мэддэг байсан Бурхан ирээдүйд зогсож, Өөрийгөө таних боломжийг бидэнд олгодог учраас бид Бурханыг мэддэг. Энэ бол угтал нигүүлслийн өгөөмөр бэлэг буюу бидний урд явж, ирээдүйд учрах нигүүлсэл юм.

Илчлэлтийг хүлээж авах боломжтой
болгохын тулд биднийг мэдэхээс ч,
хайхаас ч, туулахаас ч өмнө Бурхан
урьтаж явдаг юм.

Ээж нь дөнгөж мөлхөж байгаа нялх үрдээ анх удаа алхахыг зааж байна гэж төсөөлье. Тэгвэл ард нь гараад, живхнийх нь доороос нь гараараа эвж бариад, хөлд нь тээглэх утас уяагүй, ширээний өнцөг мөргүүлчихгүй, замд нь саад болох элдэв зүйлгүй сэлүүхэн зайтай орчныг бэлдэнэ биз дээ. Тэгээд хүүхдээ алхаарай гэж хэлээд, араас нь зөөлхөн түлхэнэ. Ингэхдээ өмнө нь хэзээ ч хийж үзээгүй үйлдлийг хүүхдээсээ хүлээнэ. Бид энэ ээжид муу дүн тавихгүй, тийм үү?

Өсөж томрох тусам хүүхдийнхээ хөгжлийг анхааралтай ажиглан, алхах гэж байгаа шинж тэмдэг илэрч буйг нь мэдсэн өөр ээжийг төсөөлөөд үзэцгээе. Энэ ээж алхах замыг нь түрүүлээд чөлөөлчихсөн, барьж авч чадах бат бөх зүйлийн хажууд хүүхдээ зогсоож, хүүхдийнхээ урд гарч, нүдний түвшинд нь өвдөглөн сууж, алгаа дэлгэн, хүүхдийг өөр лүүгээ дуудна. Энэ мөчид хүүхдийн биед ямар нэгэн зүйл болно. Хүүхэд хамгийн ойрын хүнийхээ хайранд найдан, түүнд итгэж, хормын өмнө хийж чадахгүй байсан зүйлээ чадна гэдгээ гэнэт ухаарна. Хэн нэгэн тэднийг араас нь түлхэж, шаардаж байгаа учраас биш, харин тэдний хамгийн дотны хүн өмнө нь замыг нь бэлтгэж, дараагийн мөчид тэвчээртэй хүлээн, урам зориг өгч, өөр лүүгээ дуудсан учраас л тэд ирээдүй рүү алхам хийдэг.

Арагшаа харчихаад ирээдүй өөдөө алхах хэцүү ч, яагаад ч юм, бид зүгээр л өнгөрсөн рүү хуруугаараа зааж, Бурхан өмнө нь юу хийснийг хүмүүст хэлснээрээ тэднийг Бурхантай танилцуулж чадна гэж боддог юм шиг санагддаг. Хэдийгээр энэ нь хүүхэд түшиж барих бат бөх тавилга шиг өөртөө итгэх итгэлийг өгч болох ч тэднийг амьдрал уруу алхахад дуудахын тулд ирээдүйгээс яг одоогийн мөчид нь Бурхан ирсэн гэсэн боломжийг нээж өгдөггүй. Угтал нигүүлсэл бол бидний ирээдүйд зогсож буй Бурханыг сэрээдэг юм.

Би энэ үнэнийг эртхэн мэдсэн ч болоосой гэж боддог. Библийг дандаа Бурханы хийсэн зүйлсийн талаарх өнгөрсөн түүх гэдэг өнцгөөс уншихдаа өнгөрснөөс Бурханыг олох гэдэг байжээ. Харин үнэндээ, Библи бол ирээдүйд гарч ирэх Бурханы тухай түүх юм.

Эхлэл номонд Бурхан түнэр харанхуй нөмөрсөн гүний мандал дээгүүр элин хальж, ирээдүйгээс бүтээлүүдийг бий болгохоор дуудсан тухай гардаг. (Эхлэл 1-ийг үзнэ үү).

Бурхан Абрамын өмнө явж, түүний удмаас бий болох овгоор дамжуулан бүх хүмүүсийг ерөөнө гэдгээ түүнд хэлсэн (Эхлэл 12).

Мосег хонио хариулан ирэхээс өмнө Бурхан Медианы нутагт шатаж буй бутаар дамжуулан түүнд үзэгдэн, Египетээс хашгирч байгаа ард түмнээ аврах тухайгаа хэлдэг. Ард түмэн нь өөрсдийг нь авруулахаар Мосег дуудаж байгааг ч мэдээгүй байсан юм. (Египетээс Гарсан нь 3)

Бурхан Мариас түрүүлэн явж, түүнийг жирэмсэн болох талаар тэнгэр элчээрээ хэлүүлсэн. Бурхан түүний жирэмслэлтийн тухай Иосефт ч бас түрүүлэн хэлсэн юм. (Матай 1, Лук 1)

=====

**Бурхан үргэлж ирээдүйгээс
бидэн рүү ирж, айсуй Хаанчлалдаа
урин дуудсаар байдаг.**

=====

Бурхан элч нарын ирээдүйд зогсоод, арай өөр аргаар загас бариулахаар дуудсан. (Матай 4:18-22, Лук 5:1-11)

Бурхан Лазарын булшин дээр очоод оршуулгын боолтны дотор шинэ амьсгалыг өгсөн. (Иохан 11)

Бурхан Саулаас урьтан Дамаскийн замд очсон. (Үйлс 9)

Өнгөрсөнд болсон эдгээр түүхүүд Бурхан бидний ирээдүйд оршдог бөгөөд амьдралыг маань бүтээдэг гэдэг найдварыг бидэнд өгдөг. Тэгэхээр энэ л Бурханыг бид таньж мэдэн зөвхөн Түүний бүтээж чадах ирээдүй дотор оролцож чаддаг юм. Угтал нигүүлсэл бол Бурханы аврах нигүүлслийг хүртсэний дараа дуусдаг зүйл огтхон ч биш. Бурхан үргэлж бидний өмнө явж, бүр үүнээс ч хавьгүй илүүгээр, ямагт ирээдүйгээс бидэн рүү ирж, Өөрийн хаанчлалд урин дууддаг билээ.

“Таны хаанчлал ирэх болтугай” хэмээн залбирахдаа бид өнгөрсөн, одоо, ирээдүй дэх цаг хугацаан дотор бодитоор оролцож байдаг. Энэ хаанчлал бол Есүсийн амиллалтаар баталгаажсан хаанчлал. Илчлэлтээр Есүсийг Эзэдийн Эзэн, Хаадын Хаан болохыг тунхаглан зарласан (17:14). Түүний хаанчлалын нигүүлсэл нь хүч ба оршихуйн илрэлийг танихын тулд Бурханы бидэнд нээж өгсөн одоо цагийн хором, мөч бүр билээ. Христ дотор бидэнд соёрхогдсон ирээдүй рүү бид алхан ордог юм.

Хэрэв энэ бодит үнэн үнэхээр өөрчлөгч үнэн юм бол яагаад хүмүүс энэ талаар юу ч мэддэггүй юм бол? Би ихэнхдээ үүнийг утасгүй долгион эсвэл радио дохиололтой зүйрлэдэг. Яг одоо, тухайлбал яг энэ мөчид ч гэсэн бидний огт мэдэхгүй ямар нэг зүйл байж болох юм. Хэдийгээр бид энэ мөчид Бурханыг таньж мэдэж болох байлаа ч эсэргүүцэх эрх чөлөө бас бидэнд өгөгдсөн. Нигүүлслээс татгалзах нь Бурханы

үгүйсгэдэггүй хүний эрх чөлөө юм. Энэ эрх чөлөөг бид хэдий чинээ их эдлэх тусам оршин байгаа Бурханд хандахдаа төдий чинээ их өөрсдийгөө хатууруулдаг. Бурханыг мэддэггүй найзууддаа би Бурхан ганцхан өдөр л өөртэй нь хамт байгаа мэтээр төсөөлөн Түүнтэй ярилцаж, сонсож, эрэн хайж амьдраад үзээч хэмээн санал болгодог юм. Чин сэтгэлээсээ асуумаар байгаа зүйлсээ Бурханаас асуугаад шалгаж үзэхийг хүсдэг. Хайрын урилгын үгсийг хэлэх дуу хоолойд нээлттэй байгаарай. Гэнэтийн бэлэг авахад бэлэн байгаарай. Бурханыг баттай олж болдог хүн төрөлхтөний эрэл хайгуулын томьёо байдаг гэдэгт би итгэдэг болохоор ингэж хэлээгүй юм шүү. Харин Судар болон амьдралын аль аль нь Бурхан байгааг баталдаг учраас хэлж байгаа юм.

Заримдаа Бурхан ирээдүйд маань байгаа тухай ингэж бодох нь Бурхан бидний амьдралын нарийн ширийн зүйлийг ч хүртэл аль эрт төлөвлөсөн гэж итгэхэд хүргэдэг. Ийм ойлголт нь Бурханыг тэнгэрлэг хэлбэрийн цаг уурч эсвэл ирээдүйг зөгнөгч болгон хувиргадаг бөгөөд өөрсдийн нөхцөл байдлаа харахдаа Бурханы хэлсэн зүйл нь удахгүй заавал биелэнэ гэж бодоход хүргэдэг. Хэрэв Бурхан ингэж ажилладаг байсан бол амьдрал, дэлхий ертөнц дээрх амьдралыг бий болгоход Бурханы бүтээлч хамтрагчийнхаа үүргийг биелүүлэхэд бидэнд өчүүхэн орон зайг үлдээх байсан биз. Хэрэв энэ бүгдийг урьдчилан тодорхойлж, төлөвлөдөгсөн бол Бурхан бидэнд зөвхөн урьдчилсан мэдээг хэлэхээр л гарч ирэх байлаа. Христэд итгэгч хүний амьдрал үүнээс хамаагүй илүү бүтээлч. Бурхан хүн төрөлхтнийг Адам, Ева хоёроос эхлээд өнөөгийн биднийг ч бас оролцуулаад Бүтээгчтэй хамт бүтээлцэж, захирдаг бүтээлч түншлэлд урьдаг. Бурханд хариу үйлдэл үзүүлэх үед ирээдүй тодорхой болдог. Заримдаа

энэ нь хаанчлал ирж, Бурханы хүсэл тэнгэрт биелсэн шиг газар дээр ч биелдэг дуулгавартай байдлын хариу үйлдэл байдаг бол заримдаа энэ нь хүн төрөлхтнийг хортой үр дагаварт хүргэдэг дуулгаваргүй байдлын хариу үйлдэл байж болно.

Бурханы бидэнд өгөхийг хүсч буй ирээдүй бол Есүсийн дүр төрхийн дагуу, Түүнтэй адил байдлаар шинэчлэгдэх явдал юм. Энэ бол бүх бүтээлд зориулсан Бурханы хүсэл. Бид махан бие дотроо амьсгалтай байгаа цагт Бурхан биднийг бодит байдалд урьсаар, ирээдүйн хором мөч бүрт оршсоор байх болно. Бидний амьдралыг урьдаас зохиогоогүй. Бурханы бидэнд өгдөг нигүүлслийг хэрхэн хүлээж авч байгаа эсвэл хариу өгөхгүй байгаагаас шалтгаалан амьдрал маань өдрөөс өдөрт өөрчлөгдөж байдаг. Би Нью Йоркоос Сингапур уруу аялахыг хүсвэл маш олон замыг сонгож болно. Хэрэв би өөрт өгөгдсөн өдрүүддээ хүссэн зүйлээ хийвэл зорьсон газар уруугаа ойртон очих эсвэл холдон явах ч боломжтой. Угтал нигүүлсэл нь Бурхан бидний дотор Есүсийн дүр төрхийг сэргээх зорилготойг харуулж байна. Бурхан салаа зам, мухар гудамж, уулзвар болгон дээр зогсоод биднийг амьдрал уруу хөтлөх замыг сонгоход урьсаар байвч сонголтоо бид л өөрсдөө хийнэ.

Бурхан өнөөдөр өмнө минь ирээд зогсож байна. Таны дараагийн сонголт юу байх бол?

ТЭМДЭГЛЭЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Түр зогсоод сая уншсан зүйлсээ тунгаан бодъё. Та юу сонссон бэ? Өөрийнхөө үгээр тайлбарлана уу. Тайлбарласан зүйлээ өөрийн болгоорой. Энэ бүлгээс Бурхан танд юуг илүү онцгойлон харуулж таныг илүү их бодоосой гэж хүсэж байгаа бол? Бурхан танд юу хэлж байна вэ?

ЗАЛБИРЦГААЯ

Өглөө сэрэхэд чинь Есүс таны орны хөлд зогсоод өмнө чинь байгаа өдөр лүү дуудаж байна гэж төсөөлөөрэй. Есүс бүх зүйлийг шинэ болгохоор ажиллаж байна. Энэ өдрийн тухай, Өөрийнх нь ажилд таныг хэрхэн оролцохыг Есүс танд хэлж байна уу?

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Угтал нигүүлслийг өөрийн үгээр тодорхойлоорой.

2. Өнгөрсөн, одоо, ирээдүйнхээ алинд нь Бурханыг харахыг хүсдэг вэ?

3. Анх Бурханыг яаж мэдсэн, ямар хариу үйлдэл үзүүлсэн түүхээсээ хуваалцана уу.

4. Та ирээдүйгээ хэрхэн харж байна вэ? Аль хэдийн тодорхой болсон, урьдаас төлөвлөгдсөн, эсвэл өөрийн сонгосон өдөр бүрийн адал явдалт роман шиг төсөөлж байна уу?

5. Бурханыг хараахан таньж мэдээгүй ч нээлттэй найздаа та юу гэж хэлэх вэ?

ТЭМДЭГЛЭЛ

ГЭМДЭГЛЭЛЭЭ

2-Р ДОЛОО ХОНОГ

КОРНЕЛ ПЕТР ХОЁР

Дүрслэл, бэлэг тэмдгийн хувьд Илчлэлт ном сонирхолтой байдаг бол Есүсийн эртний дагалдагчдын зэрлэг аялалаараа Үйлс ном сонирхол татдаг. Энэ номыг тодорхойлох хамгийн сайн арга бол Есүсийн цовдлолт ба амилалтын үеийг хамт туулсан зарим дагалдагчид нь “Пентекостын Хүч” хэмээх галзуу хулганад сууж, хайран амьдралаараа хорин найман бүлгийн турш хадаатай явсанд байгаа юм. Эргэлзээ, эргэлт, уналт, гэнэтийн зүйлүүд нь урьд өмнө нь төсөөлж байгаагүй аялал шиг урьдчилан таамаглах аргагүй байжээ. Бурхан ард түмнийхээ өмнө гарч ирээд, тэдэнд Өөрийн гэрч байх эрх мэдлийг өгч, дараа нь тэдний үйлчлэлийн замыг бэлтгэсэн.

Үйлс номонд гардаг амилсан Есүсийн Сүнсний үйлдлийг би гайхдаг юм. Тэд дээд өрөөнд гал мэт хэлүүд, хүчтэй үлээх салхи өөрсдийг нь хүлээж байгааг мэдээгүй байв. Янз бүрийн үндэстэн, алс хол газраас ирсэн хүн бүрт ойлгуулахын тулд тэд урьд өмнө хэзээ ч ярьж байгаагүй хэлээр Пентекостын үйл явдлыг гэрчилнэ гэдгээ мэдээгүй. Петр, Иохан хоёр ариун сүм рүү явахдаа суумгай хүнийг алхуулж, баривчлагдаж, мөн байшин доргитол залбирах болно гэдгээ огтхон ч мэдээгүй. Үйлс номын туршид бид тэд огтхон ч мэдээгүй гэж давтсаар л байна. Гэвч одоо бид Бурхан тэдний өмнө явж, үг, үйлдлийг нь удирдан чиглүүлж, Есүсийн түүхийг сонсох хүмүүсийн зүрх сэтгэлийг нээж байгааг мэдэх боллоо. Үйлс ном бол харь шашинтнуудын хөрвөлт, сайнмэдээг түгээх үйл явцад үзүүлсэн Бурханы угтал нигүүлслийн агуу түүх билээ.

=====
Христийн үйлчлэл
Үйлс ном дахь
Корнелд ирэхээс ч өмнө
Бурхан аль хэдийн энэ
үйл явдал дотор байсан.
=====

Үйлс номын миний хамгийн дуртай түүхүүдийн нэг бол 10-р бүлэгт гардаг Корнелийн тухай түүх юм. Тэр бол Кайсарид амьдардаг Ромын зуутын дарга байлаа. Эзэнт гүрний цэргийн хувьд тэрээр Кайсари дахь Бурханы хүмүүсийн нүдээр харахад харь шашинтай түрэмгий хүн. Харин түүнтэй уулзахад түүнийг Бурханаас эмээдэг, бусдад харамгүй өгдөг, байнга залбирдаг сүсэг бишрэлтэй хүн гэдгийг мэдэх болно (2-р эшлэл). Тэр яаж үүнийг хийхээ мэддэг байсан юм бол? Хэн нэгэн түүнийг Есүстэй аль хэдийн танилцуулсан уу? Тэр Дэвид Бюсикийн “Зам, Үнэн, Амь” номондоо бичсэн Христийн сайнмэдээг түгээн дэлгэрүүлэхийг хориглосон бүс нутагт Есүсийн тухай мөрөөдөж байсан хүмүүсийн нэг үү эсвэл Есүс киног үзээд энэ хүн аль хэдийн тэдэн дээр очсон гэж мэдэгдсэн овгууд байв уу?¹ Христийн үйлчлэл Үйлс ном дахь Корнелд ирэхээс ч өмнө Бурхан аль хэдийн энэ үйл явдал дотор байсан.

Нэг өдөр Корнел залбирч байтал Бурхан тэнгэр элчээр дамжуулан түүн дээр ирж, Иоппагаас Симон Петр хэмээх хүнийг дуудахыг түүнд хэлэв. Тэнгэр элч түүнд Петрийн байрлаж буй хаягийг хүртэл өгдөг. Тиймээс Корнел Петрийг авчрахаар зарц нараа илгээв (3–8-р эшлэл). Тэднийг Петрийг авчрах замд Бурхан Корнелтай уулзуулахаар Петрийг түрүүлж явуулав. Петр уулзахад хараахан бэлэн болоогүй байлаа.

Петр байрлаж буй Иоппа дахь байшингийнхаа дээвэр дээр залбирахаар гарсан бөгөөд Бурхан түүнийг тэнд хүлээж байв. Петрийн ходоод хоол идэх цаг болсныг хэлэх үед Бурхан түүнд өмнө нь Бурханы бузартсан гэж тунхагласан мөн сүсэг бишрэлтэй еврей хүмүүст идэхийг хориглодог дөрвөн хөлт амьтад, хэвлээр явагчид, шувуудаар дүүрэн том бүтээлэг мэт савыг доош буулгаж буй үзэгдэл үзүүлэв. Үзэгдэлд дуу

хоолой Петрийг босож, амьтдыг нядалж ид гэж хэлдэг. Петр ариун хүн учраас, Бурханы хуулийг мэддэг учраас үүнийг зөрчихийг хүсээгүй тул татгалздаг. Дуу хоолой Петрийг нэг зүйлийг анхаарч үзэхийг санал болгож байна. Хэрвээ Бурхан үүнийг ширээн дээр тавьж байгаа бол энэ нь тэдгээрийг бузар гэж ангилах нь Петрийн хэрэг биш гэдгийг. Энэ яриа гурван удаа давтагддаг (9–16-р эшлэл). Бурханы нигүүлсэл тууштай.

Петр дээвэр дээр толгойгоо маажиж, юу болсныг ойлгохыг хичээж байх зуур Корнелийн хүмүүс яг тэр мөчид урд хаалган дээр хүрч ирээд түүнийг сураглав. Тэд Сүнсээр илгээгдсэн тул тэднийг сонсож, хамт яв гэж Сүнс Петрт хэлдэг. Петр дуулгавартай байж, хүмүүс түүнд Корнелийн тухай ярьж, Петр тэднийг хамт хонохыг урив (17–23-р эшлэл). Петр эдгээр харь үндэстнүүдийг хүлээн авч, өөр нэгэн харь үндэстэн Корнелийг Кайсарид хүлээн авахыг зөвшөөрснөөрөө иудейчүүдийн цэвэр ариун байдлын зарчмыг илт зөрчжээ.

Маргааш нь тэд Кайсари руу хоёр өдрийн аялалаа эхлүүлнэ. Тэднийг ирэхэд Петр Иоппад үзсэн үзэгдлийнхээ талаар эргэцүүлэн бодож, энэ нь юу гэсэн үг болохыг ойлгох хангалттай цаг байсан тул тэрээр Корнел болон сонсож буй бусад бүх хүмүүст өөрийн дүгнэлтээ шууд тунхаглан: “Иудей хүний хувьд харь үндэстэнтэй нөхөрлөх буюу тэдний гэрт зочлох нь ямар ёс бус хэрэг болохыг та нар өөрсдөө мэднэ. Гэвч ямар ч хүнийг бузар, эсвэл цэвэр бус гэж нэрлэх ёсгүйг Бурхан надад харууллаа. Тиймээс дуудахад чинь би түдгэлзэлгүйгээр явж ирэв. Та нар намайг дуудсан учраа хэлнэ үү? гэв” (28–29-р эшлэл).

=====

Бурханы нигүүлсэл тууштай.

=====

Корнел Бурханы тэнгэр элчээс ирсэн түүхийг давтаж, Петрийг өөрт нь болон зочдодоо Бурханыг хүссэн бүхнээ хэлэхийг нь урьснаар Петр Христийн сайнмэдээг харь үндэстнүүдэд тунхагласан анхны иудей Христэд итгэгч болсон юм (30–43-р эшлэл). Түүнийг ярьж байх үед Ариун Сүнс цугласан олон хүн дээр буухад, Петр 2-р бүлэгт бичсэнчлэн, Сүнс өөрт нь болон түүний итгэл нэгт иудейчүүдэд ирсэн шигээ харь үндэстнүүдэд ч ирж чадна гэдгийг хараад цочирдов. Тэд бүгдээрээ Есүсийн нэр дээр Ариун Сүнсээр баптисм хүртжээ. (44–48-р эшлэл).

Бурхан дахин нэг шинэ зүйл хийсэн нь Петрийг тэрхүү түүхийн нэг хэсэг болгохоосоо өмнө түүний ойлголт, дуулгавартай байдлын замыг засахаар Петрээс түрүүлж явсан нь юм. Энэ бол угтал нигүүлсэл. Хүмүүс харь үндэстний цэргийн гэр бүлүүдэд хэрхэн хүрэх талаар төлөвлөлтийн хурал хийсэн учраас аврал Корнелийн гэрт ирээгүй. Тэд сайнмэдээ түгээх стратеги боловсруулаагүй, хөрөнгө босгож, авралын товхимол хэвлээгүй эсвэл Кайсарид айлын хаалга тогшоогүй. Бурхан хөдөлж, Сүнс хөдөлгөгдсөн учраас аврал Кайсарид ирсэн юм.

Энэ түүхээр Есүсийн талаар бага мэддэг хүн болон олон нийтийн үйлчлэлийнхээ эхэн үеэс Есүсийг дагасан хүний аль алиных нь дотор байсан угтал нигүүлслийг илчилсэн. Бурхан Корнел дээр ч ирсэн, бас Петрийг нүүр тулсан уулзалтанд бэлтгэхээр ч ирсэн. Олон хүмүүс энэ түүхийг “Корнелийн хөрвөлт” гэж нэрлэдэг ч “Петрийн ангиллын хөрвөлт” гэж бас нэрлэж болно. Бурханы нэвтрэх чадалтай нигүүлсэл нь Петрийн иудейчүүдийн уламжлалаас гадуурх аливаа зүйл бузар гэсэн үндсэн бөгөөд бүрэн үндэслэлтэй итгэлийг үгүй хийсэн. Иудеизм анхнаасаа маш онцгой шашин болон үүссэн нь үнэн боловч Бурхан үүнийг

үргэлж өргөжүүлж, нийтэд хүртээмжтэй болгохоор төлөвлөж байсан нь үнэн юм. Бурхан Абрахамыг хамгийн анх дуудахдаа түүнд Бурханы ард түмнээс бүрдсэн энэ үндэстний хүн нэг бүрийг (бүх хүн багтсан гэсэн утгатай) эцэст нь ерөөнө гэж хэлсэн (Эхлэл 12:2-3). Үйлс 10-д Бурхан хүн бүрийг Бурханы бүтээл гэж харахад нь Петрт туслахаас эхлээд, Үйлс 2-т Пентекостын өдөр иудейчүүд Ариун Сүнсний савнууд байсантай адилхан хүн бүр тийм байх боломжтой гэдгийг ойлгуулахыг илүү зорьсон.

=====

**Бурхан хөдөлж,
Сүнс хөдөлгөгдсөн учраас
аврал Кайсарид ирсэн юм.**

=====

Бидний Бурхантай хамт алхах алхаа маань шашинлаг бодол санаа, бусдыг шүүх шүүлтийн цуглуулга болох үед бидний бодол санаа, зан чанар дэлхий дээрх Бурханы үйл ажиллагаатай хөл нийлүүлэн алхахад маань саад болохуйцаар хатуурдаг. Ийм учраас нигүүлсэл бүх хэлбэрээрээ хэрэгтэй. Бурханы ариусгах ажил нь бидний ангиллыг устгаж, цэвэршүүлж, дэлхийд чиглэсэн Бурханы угтал нигүүлслийг аврах нигүүлсэл хэмээн таних боломжийг бидэнд олгодог юм. Бид нигүүлслээс нигүүлслийн хооронд амьдардаг.

Үзэл бодлын ангилал эвдэгдэх үед бид хангалттай хэмжээнд хүртлээ чимээгүй болдог ба ингэснээр Бурхан өвөр дээр маань цутган буулгадаг тэрхүү туршлагад бид нээлттэй болох шаардлагатай болдог. Биднийг харж чадаагүй эсвэл хараахан ойлгоогүй байсан ч “Пентекостын Хүч”-ний галзуу уралдаан Бурханы бидний өмнө тавьсан зам дээр хөдөлж эхэлдэг билээ. Тийм ч учраас Христэч амьдралыг “зам” гэж нэрлэдэг. Энэ бол жим, харгуй, зам, аялал, Бурхантай болон Бурхан уруу чиглэсэн адал явдал юм. Угтал нигүүлсэл биднийг аялалд урьдаг бас биднийг болон бусдыг Бурханы хийж буй зүйлд бэлтгэдэг.

Хамтдаа жаахан хөгжилдөхийг хүсч байна уу? Угтал нигүүлслийнхээ нүдний шилийг зүүгээрэй. Үйлс номыг тэрхүү тусгай нүдний шилээ зүүгээд унш, Есүсийн тухай захиасыг хүмүүст нээж өгөхийн тулд Бурхан элч нарын өмнө гарч ирэх бүх замыг олж мэд. Элч нарын хийж чадах зүйлс ба зөвхөн Бурханы хийж чадах зүйлсийг харьцуулаарай. Өөрсдийн ертөнцөд Есүсийн гар, хөл болж байхдаа өөрсдөө ч гайхширч байсан зүйлсээ тэмдэглэ. Энэ бол үнэ цэнтэй аялал шүү.

ТЭМДЭГЛЭЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Түр зогсоод сая уншсан зүйлсээ тунгаан бодъё. Та юу сонссон бэ? Өөрийнхөө үгээр тайлбарлана уу. Тайлбарласан зүйлээ өөрийн болгоорой. Энэ бүлгээс Бурхан танд юуг илүү онцгойлон харуулж таныг илүү их бодоосой гэж хүсэж байгаа бол? Бурхан танд юу хэлж байна вэ?

ЗАЛБИРЦГААЯ

Бурханы хичээнгүйлэн хайж буй хүмүүсийн тухай бодоорой. Петрийн үзэгдэл шиг, Бурханы нигүүлсэлд оролцуулахын тулд ангиллуудыг тань ариусгах шаардлагатай тэнгэрийн бүтээлэгний туршлага танд бий юу? Бидний оролцооноос үл хамааран Бурханы нигүүлсэл бусдад ч бас зориулагдсаныг санаарай. Бусдын амьдралд хийж буй Бурханы ажлыг үл хэрэгсэж, үл тоомсорлож, үгүйсгэх үед бид өөрсдийнхөө өөрчлөлтийг л богиносгосоор байдаг.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Та амьдралдаа Корнел шиг байдалд орж байсан уу?

2. Петрт тохиолдсон шиг Бурхан таны ангиллыг өөрчилсөн үе таны амьдралд байсан уу?

3. Өнөөдөр чуулганы хийх гэж оролдож буй ихэнх зүйлийг Ариун Сүнсний хүчгүйгээр хийх боломжтой гэж хэлсэн байдаг. Энэ мэдэгдлийн талаар та юу гэж бодож байна вэ? Ариун Сүнсгүйгээр хийж болох ажил үнэ цэнтэй байж чадах уу? Бурхан танаас урьтаж хийгээсэй гэж хүсч буй ямар ажлыг та хийж чадах вэ?

4. Таны итгэлийн аялал аливаа зүйлийг утга учиртай болгодог тодорхой багц итгэл үнэмшил мэт харагдаж байна уу, эсвэл ямар нэгэн зүйл тохиолдож болзошгүй зэрлэг, урьдчилан тааварлашгүй аялал шиг харагдаж байна уу?

5. Өнөөдөр танай хотод Бурхан юу хийж байна гэж та бодож байна вэ? Та хэрхэн оролцож болох вэ?

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

3-р долоо хоног

ХЭН ГЭДГИЙГ МИНЬ
ХЭЛДЭГ БУРХАН

Би амьдралынхаа дөч гаруй жилийг их сургуулийн хотхонд өнгөрөөсөн. Их сургуулийн оюутнууд бол бие даасан байдлын тэнцвэр, хүн байхын болон хамт олны дунд оршин тогтнохын утга учрыг байнга туршиж үзэж байдаг хүн амын дундах түр зуурын боловч нэлээд өвөрмөц хэсгийнхэн юм. Тэд хүүхэд насныхаа ачаа, магадгүй өнгөрсөн үеийн сэтгэлийн бэртлүүдээ үүрч, “бодит ертөнц”-ийн хатуу ирмэгт цохигдох үедээ айдас түгшүүр, сэтгэл гутрал, тодорхойгүй байдал, уур хилэн, ганцаардлыг мэдрэх нь элбэг байдаг. Үе үеийн их дээд сургуулийн оюутнууд болон залуучууд хар тамхи, хэвлэл мэдээлэл, технологи, нийгмийн дарамтуудтай тэмцсээр ирсэн. Энэ бүхэн нь хүйс, арьсны өнгө, шашин шүтлэг, улс төрийн хувьд энэ дэлхийд үнэхээр гаслантайгаар хуваагдал үүсгэж байгаа бөгөөд байсаар ч байх байх.

Зарим хүмүүсийн хувьд “бодит ертөнц” бол баяр хөөрийг хулгайлж, ирээдүйг устгаж, утга учиртай амьдралыг сүйрүүлэхээр ирдэг хулгайч юм. Бид бүгд энэ ертөнцөд амьдрахдаа ийм нөлөөллийг хүртэж л явна. Оюутан, залуучууд өөрсдийн хүн чанар, оршин буйн утга учрын төлөө тэмцэж буй анхны эсвэл цор ганц хүмүүс биш боловч эдгээр зүйлсийг илүү хурцаар авч үздэг онцгой байр суурьтай хүмүүс байж магадгүй. Оюутан, тэр дундаа залуу нас бол амь руу эсвэл үхэл рүү хөтөлдөг замтай учруулдаг бодит байдалтай нүүр тулах цаг хугацаа, орон зай байж болох бөгөөд эндээс л бид хэн гэдгээ мэдэж авч болох юм.

Би хэн бэ? Би яаж амьдрах бол? Би юу хүсч байна вэ?

Эдгээр нь бидний хэн нэгний өөрөө өөртөө хариулах хамгийн чухал асуулт байж магадгүй. Алан Нобелийн бичсэн хувь хүний мөн чанараас эхлэлтэй хувь хүний мөн чанарын зан төлвийн тухай болон эдгээр зан төлвөөс

үүдэлтэй утга учрын тухай судалгаанд би талархаж байна. Олон хүмүүсийн тайван бус түгшүүрийн гол цөм нь хүн байх нь юу гэсэн үг болохыг тодорхой ойлгохтой холбоотой. Энэ ойлголт бол бид өөрсдөө бөгөөд бид зөвхөн өөрсдөдөө харьяалагддаг төдийгүй зөвхөн өөрсөддөө л хариуцлага хүлээдэг гэсэн ойлголт юм. Хэрэв бидний дийлэнх нь үүнд итгэдэг бол хүнд өөрийн гэсэн ёс суртахууны луужин байх ёстойг ойлгож, зөв буруугийн хил хязгаараа тогтоож чадах ба ингэснээр намайг захирах эрх мэдэл өөр хүнд байх ёсгүй гэдгийг ухаарч, дэлхий дээр өөрсдийн маань бүтээсэн мөн чанарын хүлээн зөвшөөрөл, баталгаан дээр бидний үнэ цэн оршдог ба бид зөвхөн өөрсдийнхөө амьдралын утга учрыг бий болгох хариуцлага хүлээдэг гэдэгт итгэх болно.

Өөрөө өөртөө харьяалагддаг гэсэн итгэл үнэмшлийн төрөлх үр дагаврын талаар бодоцгооё. Мэдээжийн хэрэг, Бурхан бидэнд хүссэнээр маань аливааг хийх эрх чөлөөг өгдөг ч Тэр биднийг таньж, баталж, удирдаж, бидний утга учрыг тодорхойлохгүй бол хүн байхад зайлшгүй шаардлагатай энэ бүхнийг бид өөрсдөө хийх ёстой болно. Эргэн тойрны маань хүмүүс яг адилхан хоосон, сэтгэл хангалуун бус үр дүнг эрэлхийлдэг шиг бид амьдралынхаа үлдсэн хугацааг өөрийн мөн чанараа бий болгож, дахин бүтээхэд зарцуулж, өөрийгөө хэн гэдгийг батлахыг дэлхийгээс шаардаж, дэлхийгээр үнэлүүлэхээр чармайсаар л байх болно.

=====

**Амь руу эсвэл үхэл рүү хөтөлдөг
зам бий бөгөөд эндээс л бид хэн
гэдгээ мэдэж авч болно.**

=====

Бид өөрөө өөртөө хамаатай гэдэгт итгэх үед явах хоёр замыг Нобел санал болгож байна. Эхний зам бол батлах зам. Би өөрийнхөө хамгийн сайн би, өөрийнхөө үнэн, жинхэнэ хувилбар болж чадах сорилтуудыг даван туулах болно. Би илүү том, илүү сайн байхын тулд өөрийгөө сайжруулж, өөрийгөө оновчтой болгох болно. Илүү сайн байхын тулд би өөрийгөө сахилгажуулах болно. Би өөрөөсөө шалтгаалах зүйлийг хийх болно. Уншиж судлах номнууд, хувь хүний хөгжлийн тухай мэдээллүүд, гүйцэтгэлийн хэрэгслүүд гэх мэт өөрийгөө хамгийн сайнаар дэмжиж болох төгс зүйлс дэлхийд маш их болсон. Өнөөдөр миний хэдэн алхам хийсэн, хэдэн цаг Netflix үзсэн, хэр үр дүнтэй унтсан, биеийн биохимийн үзүүлэлт, дүнгийн голч, олон нийтийн сүлжээний нөлөө, найз нөхөд, миний зээлийн мэдээлэл, миний биеийн жин, уншаагүй мессеж, миний банкны үлдэгдэл гээд бүх зүйлийг дэлхий миний өмнөөс хэмждэг болсон учраас би өөрийнхөө гүйцэтгэлтэй өрсөлдөж чадахаар болсон. Өчигдрийнхөөсөө илүү байхын тулд өнөөдөр хэрхэн өөрийгөө дайчлахыг минь сануулж байгаагаараа дэлхий ертөнц намайг сайжрахад гайхалтай төгс байдлаар туслах болсон. Би өөртөө харьяалагддаг гэдэгт итгэх үедээ өөрийгөө үнэ цэнтэй болгох үүрэгтэй болж байгаа тул өөрийнхөө үнэ цэнийг таниулахыг дэлхийгээс шаардах бөгөөд ингэснээр би онцгой, хайрлагдсан нэгэн гэдгээ мэдрэх болно. Харамсалтай нь тэгсэн ч гэсэн миний бүх ололт амжилт хэзээ ч баттай сэтгэл ханамжийг өгөхөд хангалттай хүрэлцэхгүй.

Хоёр дахь нь болих зам. Магадгүй би аль хэдийн батлах замыг туулсан ч хэзээ ч тултал хангалттай хийж чадахгүй, эсвэл дэлхий надад алга ташихад хангалттай амьдарч чадахгүй гэдгээ мэдэх юм. Дэлхий намайг бусдаас онцгой, хайрлагдсан, үнэ цэнтэй гэж

хэлэхгүй гэдгийг би ойлгох болно. Байнгын өрсөлдөөн таалагдахгүй байгаа учраас би “бөмбөгөө аваад гэртээ харьж” магадгүй, ингэснээр би цагаа илүү үр дүнтэй зүйлд ашиглах ч юм билүү. Дэлхий намайг болихыг дэмжиж байгаа байх. Би өөрийнхөө зүрх сэтгэлийн доторх өвдөлтийг намдаахаар өөрийгөө сатааруулах бүхнээр өөрийгөө хангаж эхэлнэ. Мартахын тулд ууж, идэж, ажиллаж, видео тоглоом тоглож, олон нийтийн сүлжээгээр хэсэж, эцэс төгсгөлгүй нийтлэл бичиж, онлайнаар маргаж, өөрийн үзэл бодлоороо дэлхийг бүхэлд нь дэлбэлж ч чадна. Дэлхий ертөнц намайг үхэх хүртэл минь залгисаар байхын тулд сатааруулах бүх оролдлогыг хурууны үзүүрээр минь хийлгэсээр байхыг л зорьж байгаа. Би дахиж хэзээ ч өөрийнхөө мөн чанарыг бий болгож чадахааргүй болж байна. Би өөрөө өөртөө харьяалагддаг учраас зөвхөн өөрийнхөө хүссэнээр л өөрийгөө хооллох хэрэгтэй.

Тэгвэл эдгээр замуудын аль нэгэнд нь орсон бидний хувьд угтал нигүүлсэл сайн мэдээ мөн үү? Ингэж асуусандаа баяртай байна! Энэ ертөнцийн суурь худал бол бид өөрийнхөөрөө л амьдарна, бас бид зөвхөн өөрөө өөртөө хамаатай гэх ойлголт юм. Үнэн нүүр царайг нь олж харах хүртэл энэ худал хуурмаг биднийг тодорхойлж, захирч, эцэст нь устгах болно. Хүмүүс бид амьдралынхаа утга учрыг олох, өөрсдийн ёс суртахууныг тодорхойлох, өөрсдийн мөн чанарыг бий болгохын тулд бүтээгдээгүй учраас өөрийнхөөрөө байхаас залхана. “Би өөрөөрөө л байна”, “Би өөрийнхөө замыг тодорхойлно”, “Би өөрийнхөө дүрмийг өөрөө гаргана!” гэж хэлэхэд эрх чөлөө мэдрэгдэж, сэтгэл өөг байх нь мэдээж. Гэвч ийм амьдралын хэв маяг биднийг аргагүйдсэн, ядарсан, зорилгогүй, хоосон болгохоос цаашгүй.

Энэ худал хуурмагийг тодорхойлсон үг

Христитгэлийн үгсийн санд бий. Энэ үг нь “гэм нүгэл”. Нүглийн мөн чанар нь өөрийн эрх мэдэл буюу бид өөртөө хамаатай гэсэн итгэл юм. Адам, Эва хоёр цэцэрлэгт Бурханд “үгүй” гэж хэлээд, өөрсдийгөө бурхад болгох хориотой жимсийг идэж байхдаа яг ийм зүйлийг хийсэн. Бурхан тэдэнд өөрсдийнхөө замаар явахыг зөвшөөрч, харин бидний мэдэх ертөнц тэдний мөрөөр дагасан юм.

=====

**Христ доторх мөн чанар
биднийг өөрсдийнх биш
гэдгийг ойлгуулдаг.**

=====

Бидний хувьд сайн мэдээ гэвэл хүн байх гэж юу болох талаар эрс өөр ойлголттой болсон явдал юм. Бид өөрсдийнх биш, харин Христэд харьяалагддаг. Бидний мөн чанар Христ дотор байдаг. Бидний арга зам, үйлдэл, зан авирыг Христ удирддаг. Бидний утга учир нь Христ суурьтай. Бурхан биднийг хэн болохыг, Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн үнэ цэнтэй гэдгийг, бид хүмүүст хамаатай, ертөнцийн худал хуурмагаас чөлөөлөхийн тулд Бурхан цорын ганц Хүүгээ бидний өмнөөс үхүүлэхээр илгээсэн учраас бид маш ихээр хайрлагдсан хүмүүс гэдгийг хэлдэг. Энэ л Бурхан бидний мөн чанарыг баталж, Бурханы бүтээсэн итгэлийн хүн төрөлхтний жинхэнэ илэрхийлэл рүү биднийг чиглүүлдэг.

Тийм ээ, Христ доторх мөн чанар нь өөр нэг хүн бидний юу хийж, хэрхэн амьдрахын дээгүүр эрх мэдэлтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөг, учир нь Христ доторх мөн чанар нь биднийг өөрсдийнх биш гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ Христ дотор бид хэзээ ч үнэ цэндээ эргэлзэх, үнэ цэнээ батлах эсвэл батлахын төлөө тэмцэх шаардлагагүй. Ертөнц биднийг хэзээ ч хайрлаж байгаагүйгээр Бурхан биднийг хайрладаг тул Бурхан бидэнд энэ бүхнийг үнэ төлбөргүй өгдөг. Бид энэ үнэнийг мэдэж чадвал энэ үнэн биднийг чөлөөлөх болно.

“Иймд ах дүү нар аа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя. Энэ нь та нарын сүнслэг мөргөл мөн. Энэ үеийн явдалд бүү нийцэгтүн. Харин зүрх сэтгэлээ шинэчилснээр өөрчлөгдөж Бурханы хүсэл юу болохыг, тухайлбал сайн, тааламжит, төгс төгөлдөр хүслийг батлагтун” (Ром 12:1-2). Хүний үйлдлээрээ баталгаатай гэсэн замыг туулж, өөрийнхөө үнэ цэнийг нотлохыг хичээж байсан,

дотроо бодолтой, хичээл зүтгэлтэй еврей хүн болох элч Паул энэ урилгыг бичиж үлдээсэн юм (Филиппой 3:4–6). Дараа нь тэрээр Есүстэй уулзаж, Дамаск хүрэх замд түүний өмнө гарч ирсэн нигүүлслийг бүрэн мэдэрчээ (Үйлс 9). Тэнд л Бурхан түүнд хэн байсныг нь хэлсэн. Паулын гэрчлэлийг Филиппой 3:46–11-ээс харна уу.

Ургийн бичгийг нь харвал, хууль ёсны дагуу төрсөн, төрөөд найм дахь хоногтоо хөвч хөндүүлсэн, дээд гаралтай Бениамин овгийн Израйл үндэстэн, Бурханы Хуулийг чандлан сахидаг, сүмийг хавчих хүртлээ шашныхаа цэвэр ариун байдлыг хамгаалсан, Бурханы Хуулийн номд заасан бүх зүйлийг няхуур авч үздэг байсан гэжээ. Хүмүүсийн онцгой хэмээн үзэж, эргэн тойронд минь даллан дуудаж байгаа чухал гэгдэх зүйлсийг, мөн өөрийн хувьд үнэ цэнтэйд тооцож байсан зүйлсээ ч бүгдийг нь урж, хог мэт хаяж байна. Яагаад гэж үү? Христийн улмаас. Тиймээ, нэгэн цагт миний хувьд маш чухал гэж бодож байсан бүх зүйл амьдралаас минь алга болсон. Христ Есүсийг өөрийн Эзэн гэдгээ мэдэх асар их аз завшаантай харьцуулахад өмнө нь өөрийнхөө төлөө явж байна гэж бодож байсан бүхэн нохойн жогорхой шиг тийм ч чухал биш байжээ. Би Христийг тэвэрч, Түүгээр өөрийгөө тэврүүлэхийн тулд бүгдийг нь хог уруу хаясан. Би Христэд болон Бурханы зөвт байдалд итгэснээр ирэх бат суурийг олж авахын тулд дүрэм журмын жагсаалтыг баримталсны үр дүнд бий болдог өчүүхэн, дорой зөвт байдлыг хүсээгүй. Би Христийг хувьчлан таньж, Түүний амилалтын хүчийг мэдэрч, Түүний зовлон зүдгүүрийн хамтрагч болж, үхэх хүртэл Түүнтэй хамт явахын тулд өөрийгөө дорой болгодог бүх зүйлээ орхисон. Хэрэв үхлээс амилах зам байгаа бол би амилахыг хүсч байна.

Паул захидалдаа өөрийгөө Есүс Христийн боол

гэж танилцуулдаг зуршилтай болсон нь гайхах зүйл биш юм. Тэр өөрийнх биш, Христийнх гэдгээ мэдсэн. Тэрээр өөрийн утга учир, Христийн харьяаллаа олсон. Тэр Христээр хайрлагдаж, үнэлэгдэж, батлуулсан. Тэр Христээр чиглүүлэгдэж, удирдуулж, сургагдсан. Яг энэ Паул “Учир нь би Бурханд амьд байхын тулд Хуульд Хуулиар үхсэн. Би Христтэй хамт цовдлогдсон. Амьд байгаа нь би биш, харин миний дотор Христ амьд байна. Эдүгээ би махан биедээ амьд байгаа нь намайг хайрлаж, миний төлөө Өөрийгөө тушаасан Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч буй хэрэг юм” гэж бичжээ. (Галат 2:19б–20).

Угтал нигүүлсэл бол бидэнд зөвхөн сайхан мэдрэмж төрүүлдэг теологийн сайхан хэсэг биш ээ. Угтал нигүүлслээс бид хүн болдог. Эндээс л бид хэн бэ гэдгээ мэдэж эхэлдэг юм. Энэ бол амь руу хүргэх хурдны зам юм. Бурхан бидэнд зам зааж өгөхөөр ирсэн бөгөөд энэ бүхэн Бурханы угтал нигүүлслийн улмаас бид хэн болохоо мэдэхээс эхэлнэ.

ТЭМДЭГЛЭЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Түр зогсоод сая уншсан зүйлсээ тунгаан бодъё. Та юу сонссон бэ? Өөрийнхөө үгээр тайлбарлана уу. Тайлбарласан зүйлээ өөрийн болгоорой. Энэ бүлгээс Бурхан танд юуг илүү онцгойлон харуулж таныг илүү их бодоосой гэж хүсэж байгаа бол? Бурхан танд юу хэлж байна вэ?

ЗАЛБИРЦГААЯ

Өөрийгөө хэн гэдгийг Бурханд хэлээрэй. Бурханд хандан залбирлаа бичиж байхад тань эхийн хэвлийд таныг шагласан, үсний ширхэг бүрийг, бодол болгоныг чинь мэддэг, алхам тутамд таныг хайрладаг Тэр Бурхан, Өөрийн амилсан Хүү Есүсийн хүч чадлаар таны нэр төр, амьдралын зам, утга учир байх болтугай.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Бид өөртөө харьяалагддаг гэсэн итгэл үнэмшил нь яагаад хүмүүсийн хувьд аливаа хүссэн зүйлээ өөрийн дураар хийх нийтлэг хамгаалалт болсон бэ?

2. Би өөрийгөө захирдаг гэсэн худал ойлголтыг угтал нигүүлсэл хэрхэн нэвтэлж байна вэ?

3. Дэлхийд танигдсан тоглоомонд ороход яагаад ийм амархан байдаг вэ?

4. Өөртөө харьяалагдахаа больж, Христ дотор өөрийнхөө мөн чанарыг олж мэдсэн тэр мөчийнхөө талаар хуваалцана уу.

5. Филиппойчуудад өгсөн Паулын гэрчлэл таныхтай юугаараа төстэй эсвэл ялгаатай вэ?

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

4-Р ДОЛОО ХОНОГ

БИ СОНГОГДОХ
ДУРТАЙ

Угтал нигүүслийн талаар ярихад тэнгэрлэг сонголт ба хувь тавилангийн тухай ярианы голд биднийг яах аргагүй аваачих болно. Үүнийг ойлгохын тулд Шинэчлэлийн ба Уэслийн гэсэн хоёр арга замыг судлах хэрэгтэй болно.

Шинэчлэлийн тухай (зарим нь Калвинистууд ч гэдэг) ойлголт нь Бурхан хэсэг бүлэг хүмүүсийг аврахаар сонгосон гэж үздэг. Үүнийг өөрөөр тайлбарлавал Бурхан тэдэнд аврагдах “тавилан” өгсөн буюу Бурханы авралын бэлэгт өгөх хариулт ба хүлээн авах чадварыг нь урьдаас тогтоочихсон гэсэн утгатай. Шинэчлэлийн үзэл баримтлал нь мөнхийн аюулгүй байдлын урилгыг бүх хүнд сонсгох боломжийг олгодог боловч зөвхөн сонгогдсон хүмүүс л итгэж, аврагдах эрхтэй гэж үздэг. Хүмүүс Бурханаар сонгогдсоны дараа Бурханы нигүүлслээс зугатах аргагүй буюу Бурханы аврах нигүүлслийг эсэргүүцэж, өөрсдийгөө “аврагдахгүй” болгох сонголтгүй болдог гэсэн үг юм. Тэд нэгэнт аврагдсан бол тэдний авралыг хүчингүй болгохын тулд юу ч хийж чадахгүй. Тэд Христ дотор мөнхөд аюулгүй байна. Шинэчлэлийн нөхдүүд маань үүнийг арай өөрөөр тайлбарлаж магадгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, юутай ч Шинэчлэлийн байр суурийг товчхондоо ийнхүү хүргэж байна.

Уэсличүүд авралын тухайд Бурхан бүх хүнийг аврахын хүсдэг гэж үздэг. Алдагдсан хонь, гэсэн зоос, төөрсөн хүүгийн тухай сургаалт зүйрлэлүүдийн нэгэн адил Уэсличүүд Бурхан төөрсөн бүтээл бүрийг эрэн хайдаг гэсэн итгэл үнэмшлийг баталдаг. Түүнд итгэдэг бүх хүн аврагдах болно гэдгийг Бурхан урьдчилан тогтоосон буюу урьдчилан төлөвлөсөн. Өөрөөр хэлбэл, Уэсличүүд хүн авралаа сонгох боломжтой гэдэгт итгэдэг. Аврал хүн бүрт өгөгдсөн ч тэд угтал нигүүлсэлд хариулдаггүй. Бурхан бидний

сонгох чадамжийг үнэлдэг төдийгүй байнга Бурханы нигүүлслийн бэлгийг эсэргүүцэх хүч болгохын оронд хүлээн авах буюу татгалзах чадварыг бидэнд өгсөн. Энэ нь, Бурханы нигүүлслийг хүлээн авч, амьдралынхаа аль нэг мөчид аврагдсан хүн хожим амьдралдаа яг тэр ижил нигүүлслээс татгалзаж, Бурханы замаас холдон, авралаа алдаж магадгүй гэсэн утгатай. Бидний Христтэй хамт алхах эсвэл замаасаа буцах эрх чөлөө нь Бурханы бидэнд өгсөн чөлөөт хүслийн бэлгээр хангагддаг.

=====

**Бидний Христтэй хамт алхах эсвэл
замаасаа буцах эрх чөлөө нь Бурханы
бидэнд өгсөн чөлөөт хүслийн бэлгээр
хангагддаг.**

=====

Би хувьдаа Уэсличүүдийн энэ санаанд дуртай, учир нь Боб Бэнсоны хэлснээр “би сонгогдох дуртай.” Намайг бага байхад Бэнсон миний ерөнхийлөгчөөр нь ажиллаж байсан их сургуулийн Библийн цагт байнга ирж номлодог байсан ба нүдээ анихад энэ туранхай, чанга дуутай эр урд зогсоод Бурханы тухай сурч мэдсэн зүйлээ хуваалцаж байгааг одоо ч харах шиг болж байна. Сонгогдсон тухай түүхтэй холбоотойгоор Бэнсон давжаа биетэй, туранхай хүүхэд байх үеийнхээ болсон явдалтай Бурханы угтал нигүүлслийн талаарх ижил төстэй ойлголтыг харьцуулан ярьж байсан юм. Түүний ярьснаар...

Би багадаа сул дорой хүүхэд байлаа. Биеийн тамирын хичээлээ гадаа ордог байсныг санаж байна. Манай ангийн хамгийн том биетэй, хүчтэй хоёр хүүхэд үргэлж л софтболын багийн ахлагч болдог байв. Тэд талбайн хамгийн тохиромжтой байрлалыг эзэлж, хүүхдүүдийг сонгоно. Спортын ур чадвар, найзалдаг эсэх, биеийн хэмжээ зэргээр нь хүүхдүүдийг нэг нэгээр нь дуудсаар бүгдийг нь багтаа хуваарилдаг байлаа. За бараг л бүгдийг нь дээ.

“Аль нэг баг нь Бобыг авах хүртэл тоглоом эхлэхгүй шүү” гэж багш шаардана.

Тэгэхээр нь нэг багийнх нь ахлагч нь газар өшиглөн, дуртай дургүй “за манайх авъяа” гэдэгсэн.

Намайг ер нь бараг хөдөлгөөн хийхгүй байрлалд зогсоочихдог байсан юм. Наймдугаар ангид орох хүртлээ би бөмбөг цохиж үзээгүй юм даг. Цохьё ч гэж хүсддэггүй байсан даа.

Гэхдээ сонгогдоход гоё байсан.

=====

**Тэр намайг дуудах ямар нэг
зүйл надад байгаагүй.**

=====

Тиймээс, би яагаад байж боломгүй, ямар ч логикгүй сонголт болсноо төвөггүй ойлгосон. Хэрэв миний талаар бага ч гэсэн мэддэг хүмүүс тэгэхээс өөр аргагүй байсныг минь мэдэж байвал өөрийнхөө тухай мэддэг бүхнээ мэдэх нь надад том зүйл болохыг бодоорой гэж би хэлмээр байна. Аз болоход миний сонгосон хүн надаас урган гарч ирдэггүй, зүгээр л би бол сонгогдсон хүн.

Сонголт хийсэн хүний зүрх сэтгэлд хариулт нь байх ёстой. Бурхан намайг дуудахад хүргэсэн зүйл нь миний доторх ямар нэг зүйл биш байсан. Харин Бурханд ямар нэгэн зүйл байсан. Энэ нь Түүний намайг гэсэн хайраас эхлэлтэй. Есүсийн хэлсэн “Та нар намайг сонгоогүй. Би та нарыг сонгосон” гэсэн энэ үг ямар сонголонтой үгс вэ.

Би Есүс Христ рүү ирээд, Түүнийг харахдаа миний дотроос ямар нэгэн зүйл Түүнтэй уулзахаар булгилан гарч ирээд, Түүнээс зууран, дотор хүнийг минь ил гаргаж, намайг миний мөрөөдлийн хүн болгоод өгөөч гэж гуйсан юм биш. Тэр над уруу ирсэн юм. Түүний зүрх сэтгэл над руу урссан. Тэр намайг тэвэрсэн. Тэр намайг миний хүссэн хүн болгоно гэж хэлсэн. Тэр намайг харсан. Тэр намайг хайрлаж, сонгосон. Би түүнийг олоогүй. Харин Тэр намайг олсон.

Гэхдээ үйлчлэхийг хүсээгүй хэн нэгэн хүний оронд намайг сонгоогүй. Хэн нэгэн аль хэдийн эзэлсэн талбайн нэг хэсэгт тоглохыг надаас хүсээгүй. Тэр намайг харсан, Тэр намайг дуудсан, Тэр намайг сонгосон, Тэр намайг авсан, Тэр намайг онцолсон, Тэр намайг аврахаар шийдсэн, Тэр намайг Өөртөө авсан, Тэр над дээр харцаа тогтоосон, Тэр намайг таалан соёрхсон, Тэр намайг илүүд үзсэн, Тэр надад санаа тавьсан. Тэр намайг сонгосон.

Тэр надаас татгалзаагүй, намайг эсэргүүцээгүй,

намайг үгүйсгээгүй, намайг хөөгөөгүй, надаас зугтаагүй. Тэр намайг үл тоомсорлож, үл ойшоож, хаяж, түлхэж, орхионгүй. Тэр намайг сонгосон.

Заавал, нэр хүндийн улмаас, шаардлагатай болохоор, дуудагдсан, гавьяатай, хэрэгтэй, зайлшгүй учраас, албадлагаар, хүчээр сонгосон юм биш. Тэр зүгээр л намайг сонгосон.

Энэ бол Түүний нээлттэй, сайн дурын, хүслийн улмаас хийсэн сонгомол, туйлын, зорилготой сонголт байсан юм. Тэр намайг сонгосон.

Өөрийн чин хүсэл, хайр халамж, хүндлэл, сайхан сэтгэл, санаа тавилт, хамаарал, сэтгэл хөдлөл, өрөвч сэтгэл, зориулалт, хайрын улмаас Тэр намайг зүгээр л сонгосон.

ТЭМДЭГЛЭЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Түр зогсоод сая уншсан зүйлсээ тунгаан бодъё. Та юу сонссон бэ? Өөрийнхөө үгээр тайлбарлана уу. Тайлбарласан зүйлээ өөрийн болгоорой. Энэ бүлгээс Бурхан танд юуг илүү онцгойлон харуулж таныг илүү их бодоосой гэж хүсэж байгаа бол? Бурхан танд юу хэлж байна вэ?

ЗАЛБИРЦГААЯ

Та Бурханд хүрч чадахгүй байхад танд хүрч байсан хайрынх нь төлөө өөрийн үгээр Бурханд талархаарай.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

1. Эргээд харахаар, Бурхан угаасаа тэгж төлөвлөсний дагуу Түүний нигүүлслийг хүмүүс эсэргүүцэх боломжгүй гэж авралын талаарх Шинэчлэлийн хувилбар нь хамгийн зөв гэж зарим хүмүүс үздэг. Харин маргааш уруугаа харвал, Бурхан биднийг хариуцлагатай сонголт хийх чадвартай болгосон ч бидэнд ямар нэгэн зүйл тулгадаггүй учраас Уэслийн хувилбар хамгийн утга учиртай гэж үздэг өөр хүмүүс ч бий. Аль тайлбар танд хамгийн утга учиртай санагдаж байна вэ?

2. Сонгогдох нь сонгогдсон хүний ур чадвараас илүү сонгосон хүний сэтгэл зүрхтэй холбоотой гэж Боб Бэнсон хэлжээ. Энэ ямар утгатай вэ?

3. Бид яагаад өөрсдийгөө Бурханы нигүүлсэлд зохистой болгох ёстой гэдэгт итгэдэг вэ? Үүнийг хаанаас сурах вэ?

4. Өнөөгийн дэлхийд Бурханы хайрладаг, эрэн хайдаг, судалдаг нигүүлслийн сайн мэдээ хэр бодит байна вэ? Та Бурханыг мэдэхгүй хүнд үүнийг яаж хэлэх вэ?

5. Та сүүлийн дөрвөн долоо хоногт угтал нигүүлслийн талаар юу сурч, мэдсэн бэ?

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

УГТАА НИГҮҮЛСЭЛ

Бурханы хязгааргүй хайр урд маань түрүүлэн явж, биднийг урин дуудаж, бэлтгэж, надад Бурхан хэрэгтэй эсэхээ ч мэдээгүй явахад тэвчээртэйгээр хүлээсээр байдаг билээ. Бурхан дэлхий ертөнцийг аварч, сэргээх үйлчлэлдээ Өөртэйгээ хамт үйлчлүүлэхээр биднийг сонгохдоо өмнөх замыг маань бэлдэж өгдөг юм. Харин бидний хийх зүйл бол Түүнд хариулах! Бүлэг бүрт угтал нигүүлслийн мөн чанарын талаар тусгасан бөгөөд бичиж тэмдэглэх, залбирах, төгсгөлд нь жижиг бүлэгт зориулсан асуулт, ярилцлагын хэсэгтэй.

НИГҮҮЛСЛИЙН АЯНЫ ЦУВРАЛУУД

Ахин дахин үнэгүй өгөгдсөн Бурханы нигүүлсэл нь бүхий л хэлбэрээр бидэнд хэрэгтэй тэрхүү нигүүлсэл мөн. Бидний хэлдгээр, Христэч амьдрал бол нигүүлслээс нигүүлслийн хооронд өрнөдөг. Бурхан бидний замыг бэлтгэхийн тулд бидний урд алхдаг. Бурхан биднийг аварч, гэмээс чөлөөлсөн. Тэрээр биднийг ариун байдлын замаар удирдан дагуулдаг. Дөрвөн долоо хоногийн хугацаанд үзэх хичээл тус бүрээр бид Өөрийн хүмүүстээ өгсөн Бурханы олон төрлийн өгөөмөр хайрынх нь талаар илүү гүнзгий судлах бөгөөд ийнхүү бидний итгэлийн амьдрал жинхэнэ Нигүүлслийн Аялал болох болно.

ДЭН БҮҮН нь Трэвэка Назарын Их Сургуулийн (АНУ-ын Нэшвилл дэх) ерөнхийлөгчөөр ажилладаг. Тэрээр Назарын Теологийн Сургууль болон МоКормик Теологийн Сургуульд тус тус суралцан, Дивинити Магистр, Министри Магистрийн зэрэг хамгаалжээ. Бүүн хэд хэдэн шилдэг борлуулалт бүхий номын зохиогч билээ.